

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24-аадар

Дугаар № 02

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан тэнцлийн дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1."Дарханы дулааны цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компанийн
2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тэнцлийн дүнг "Сайн" гэж
дүгнэсүгэй.

2.Компанийн 2019 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зорилтот түвшинг
биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү,
төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай
арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Даваасүрэн/-д
даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:

М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУПАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

C.БАЯР-ЭРДЭНЭ

60921 1118262

СБХ-т
Азгийн зохицалын
худалдааны оршиод
2020
5/07.

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар № 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны
2019 оны ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:


1.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны 2019 оны үйл ажиллагааг “Сайн”
гэж үзсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн компанийн
өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил
үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу явуулахад хяналт тавьж, үр
дүнтэй, санаачилгатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Даваасүрэн/-д
даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ
6098161 - 1118262

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар № 04

Улаанбаатар хот


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны
зардлын төсөв батлах тухай


"Компанийн тухай хууль"-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтыг
үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг хавсралтын дагуу
баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн
удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал, Аудитын хороодод даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:

M.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар № 05


Улаанбаатар хот

2019 оны ногдол ашгийн тухай

"Компанийн тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.8, 62.1.15, 62.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр 40,200,081 /Дөчин сая хоёр зуун мянга наян нэгэн/ төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул ногдол ашиг 15 хувиар тооцож улсын төсөвт төвлөрүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ



"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24-аадар

Дугаар №: 06

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулалт олгох түр журам"-ын 2.6, 2.7, 2.8, 2.9, 3.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 94 дүгээр тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн 7.3.10 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын 2.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан тул "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2019 оны контрактын биелэлтийг "Сайн" гэж дүгнэсүгэй.


2. Контрактаар хулээсэн үүргээ "Сайн" биелүүлсэн гүйцэтгэх захирлын контрактыг 1 /нэг/ жилээр сунгахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Даваасүрэн/-д даалгасугай.


3. Гүйцэтгэх захирал М.Жаргалсайханы 2019 оны контрактын биелэлт, ажлын үр дүнг үндэслэн холбогдох журмын дагуу урамшууллыг тооцож олгохыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

4. Дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх, зардал хямдруулах талаар удирдлага зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /М.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга /Б.Энхтуул, Л.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:

М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БӨДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

6098169 1118262983